



ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А126

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод хяналтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмыг нийт ажилтанд танилцуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны А/36 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар”, 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хоёр шатны хяналтын журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

161220425

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
20 24 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 11/26
дугаар тушаалын хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид “төв” гэх/-ын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод хяналтын журам” /цаашид “журам” гэх/-ын зорилго нь ХАБЭА-н хууль тогтоомж, техникийн норм, бичиг баримт, журам, дүрэм, зааврын шаардлагын болон ХАБЭА-н талаар төлөвлөгдсөн ажлын биелэлтийн түвшин, чанар, төвийн ажилтнуудын ХАБЭА-н талаарх ажил үүргийн биелэлт, ажлын байрны болон ажил гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангаж буй эсэхийг шалгах, хяналт тавих, үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Журам нь дараах хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг үндэслэн боловсруулагдсан болно. Үүнд:

- Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Олон Улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт OHSAS 18001:2007;
- Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо- Шаардлага MNS OHSAS 18001:2014;
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”;

1.3. Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж байгаа галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмуудыг тухайн объектод ажиллах үед тусгайлан дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү журам нь ажлын байранд, ажлаас гадуур зарим үйл ажиллагаанд оролцох болон дотоод хяналт шалгалтаар ажиллах үед мөрдөгдөнө.

1.5. Журам нь ажилтны хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохион байгуулалтын болон техник, технологийн мөрдлөг болгож ажиллах чиглэл бөгөөд энэхүү журмын нэг хэсэг болно.

1.6. Журам нь ажилтны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, албан томилолтын зорилго, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог зэргийг харгалзан тухайн үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн, үүсч болох эрсдлийг нарийн тооцоолсон, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэхүйц цогц байдлыг хангасан байна.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт

2.1. Төв нь хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус ажилтан /цаашид “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан” гэх/-тай байх бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангахтай холбогдох ажлыг зохион байгуулна.

2.2. Төвийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд хяналт тавих, төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах орон тооны бус ХАБЭА-н комиссыг захирлын тушаалаар байгуулна.

2.3. ХАБЭА-н комисс нь төвийн хэмжээнд баримтлах ХАБЭА-н бодлого, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавина.

2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан дараах ажлыг зохион байгуулна. Үүнд:

2.4.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд шаардагдах төсвийн тооцоолол хийх;

2.4.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлуулан, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

2.4.3. төвийн үйл ажиллагааны онцлогт тулгуурлан үйлдвэрлэлийн осол /ҮО/, мэргэжлээс шалтгаалах өвчин /МШӨ/, хурц хордлого /ХХ/-ын талаар сургалт хийж, зөвлөмж өгөх;

2.4.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мэдээлэл авах, илтгэл сонсгол хийх, хөдөлмөрийн сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар санал гаргах;

2.4.5. холбогдох ном, гарын авлага захиалж, төвийн удирдлагууд болон ажилтныг мэдээллээр хангах;

2.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшүүлэх сургалтад нэгжийн дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нарыг заавал хамруулна.

Гурав. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй

3.1. Ажилтан бүр ажил эхлэхийн өмнө 15 минутаас багагүй хугацаагаар ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд удирдах ажилтанд мэдэгдэж, зөрчлийг арилгах арга хэмжээг авсаны дараа ажлаа эхэлнэ.

3.2. Хортой бөгөөд аюултай бодисыг ажлын байранд ил задгай орхих, нэр хаяггүй саванд байлгахыг хатуу хориглоно.

3.3. Ажлын байранд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжид техникийн паспортын бүртгэл хөтөлнө.

3.4. Ажлын байр нь стандартын шаардлага хангасан агааржуулалтын системтэй байна.

3.5. Ажлын байр нь 1 ажилтанд 6 м² талбай ногдохоор зохион байгуулагдах ба хүйтний улиралд 22-24 градус дулаан, дулааны улиралд 23-25 градус дулаан, ажлын байрны харьцангуй чийглэг 40-60% байна.

3.6. Ажлын байр нь 50-75 дицбалл /дБА/-ээс ихгүй дуу шуугиантай байх бөгөөд гэрэлтүүлгийг өдрийн гэрлийн эх үүсвэртэй бол 300 люкс /лк/, улайсдаг гэрлийн эх үүсвэртэй бол 750 лк, нарийн ажиллагаа шаардсан ажлын байранд 1000 лк хүртэл нэмэгдүүлж болно.

3.7. Ажлын байрны цахилгаан статик орны хүчдлийн түвшин цагт 20 киловатт /кВ/-аас ихгүй байна.

3.8. Ажлын байрны гэрэлтүүлэг, дуу, шуугиан, агаарын чийглэг, дулаан зэргийг тусгай багажаар хэмжилт хийж, тэмдэглэл, бүртгэл хийж байна.

3.9. Техник, тоног төхөөрөмж бүр ашиглалт, аюулгүй ажиллагааны заавартай байна.

3.10. Тоног төхөөрөмж нь стандартын шаардлага хангасан хамгаалалтын газардуулгатай байна. Газардуулгыг жилд 1-ээс доошгүй удаа туршиж актаар баталгаажсан байх ба шалнаас 15 см өндөрт, 3 см-ийн өргөн 3 мм зузаантай туузан төмрөөр хийгдэж, хар өнгөөр будаж, сул залгаасгүй хийсэн /контактгүй/ байна.

3.11. Ажлын байранд аливаа засварын ажлыг мэргэжлийн байгууллага /мэргэжилтэн, мэргэжлийн ажилчин/-аар гүйцэтгүүлнэ.

Дөрөв. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, зааварчилгаа

4.1. Энэхүү журмын 1.4-т заасныг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа /цаашид зааварчилгаа гэх/ өгнө.

4.2. Зааварчилгаа нь хэлзүйн хоёрдмол утгагүй, товч тодорхой байх ба зааварчилгааг өгсөн болон авсан хүний гарын үсгээр баталгаажуулна.

4.3. Аливаа машин механизм, техник, тоног төхөөрөмжийг дур мэдэн гардан ажиллуулж шалгахыг хориглоно.

4.4. Ажлын байранд унах, нурах, тэсрэх, дэлбэрэх, түлэгдэх, цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, хагарах, зориулалтын бус зүйлээр таглагдсан нүх зэрэг аюултай хүчин зүйл байгаа эсэхэд анхаарч, сонор сэрэмжтэй ажиллана.

4.5. Задгай зайн хураагуурын техникийн болон ашиглалтын байдалд хяналт шалгалт хийхийн өмнө 15 минутаас багагүй хугацаагаар агааржуулах системийг ажиллуулсны дараа орохыг зөвшөөрөх ба гал гаргахыг хатуу хориглоно.

4.6. Цахилгаан тоног төхөөрөмжийн ил задгай утасны үзүүрийг хамгаалах хэрэгсэлгүйгээр барихыг хориглоно.

4.7. Цахилгаан тоног төхөөрөмжийн гар салгуур, залгуурт анхааруулах, сануулах, хориглох тэмдэглэгээ байрлуулсан байх бөгөөд дохио тэмдгийг зөрчиж, дур мэдэн салгах, залгахыг хориглоно.

4.8. Хорт хий хуримтлагдсан байж болзошгүй байр болон харанхуй хонгил, химийн бодис хадгалагдсан газарт ил гал гаргахыг хориглоно.

4.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа нь дараах төрөлтэй байна.
Үүнд:

4.9.1. урьдчилсан зааварчилгаа

4.9.2. анхан шатны зааварчилгаа

4.9.3. давтан зааварчилгаа /төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус/

4.10. Анхан болон урьдчилсан, төлөвлөгөөт давтан зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан өгнө. Анхан шатны зааварчилгааг 1 цагаас доошгүй хугацаатайгаар өгч, бүртгэл хөтөлнө.

4.11. Урьдчилсан зааварчилгаа нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, заавар, улсын стандарт, байгууллагын өвөрмөгц онцлог, дотоод журам, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхан шатны тусламж зэрэг асуудлыг хамарна.

4. 12. Анхан шатны зааварчилгааг дараах тохиолдолд өгч, бүртгэл хөтөлнө:

4.12.1. ажлын байр өөрчлөгдөх, ажилд шинээр орсон хүмүүс, дадлага хийхээр ирж буй оюутан сурагчдад;

4.12.2. гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгслүүд, тэдгээрийг хадгалах ба ашиглах талаар;

4.12.3. осолдогчдод үзүүлэх эмнэлгийн анхны тусламжийн талаар.

4.13. Давтан зааварчилгааг дараах тохиолдолд өгч, бүртгэл хөтөлнө:

4.13.1. ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах;

4.13.2. ажил, үйлчилгээний технологи, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлд өөрчлөлт орох буюу шинэчлэгдэх, шинэ дүрэм, заавар, норм, стандарт мөрдөх үед;

4.13.3. улиралд нэг удаа нийт ажилтныг давтан сургах хэлбэрээр;

4.13.4. хөдөлмөрийн нөхцөлд өөрчлөлт орох, байгалийн гамшиг, цаг агаарын тааламжгүй нөхцөлд, техник, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах, осол гарсан үед, ажилтан албан томилолтоор ажиллах болон үндсэн ажлаас өөр ажил үүрэг гүйцэтгэх үед;

4.13.5. шинэ техник, технологи, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл нэвтрүүлэх үед;

4.13.6. аюулгүйн техникийн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн осол гаргасан ажилтанд;

4.13.7. жирэмсэний болон хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаанаар 6 сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрөн эргэж ажилдаа орсон ажилтанд;

4.13.8. нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрээр томилогдсон ажилтанд;

- 4.13.9. олон нийтийн арга хэмжээнд оролцох ажилтанд шаардлагатай тохиолдолд;
4.13.10. гадаад оронд зохион байгуулагдах сургалтад хамрагдах ажилтанд.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод хяналт

5.1. ХАБЭА-н дотоод хяналтын журмаар дараах төрлийн шалгалтаар доор дурдсан үйл ажиллагааг шалгаж, дүгнэнэ. Үүнд:

- ✚ I шатны хяналт;
- ✚ II шатны хяналт;
- ✚ зорилтод хяналт

5.1.1. ХАБЭА-ны тухай хууль, дүрэм, энэ журам түүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны биелэлтийг шалгах;

5.1.1. ажлын байрны орчны аюулыг тогтоох, эрсдэлийг үнэлэх, хяналтыг тодорхойлох үйл ажиллагааг шалгах;

5.1.2. ХАБЭА-н нөхцөл байдлыг сайжруулах иж бүрэн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг шалгах;

5.1.3. ажилтнуудын ХАБЭА-н талаарх мэдлэг чадвар, тэдгээрийн ХАБЭА-н сургалтад хамрагдсан байдлыг шалгах;

5.1.4. ХАБЭА-н тухай хууль болон гамшгийн тухай хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах ба хариу арга хэмжээний бэлэн байдлыг шалгах;

5.2. I шатны хяналтын явцад ажлын байрны нөхцөл байдал нь ХАБЭА-н шаардлагад нийцэж, ажлыг аюулгүй гүйцэтгэж байгаа болон ажилтнууд нь ажилд шаардлагатай тоног, төхөөрөмж хэрэгсэлтэй, тэдгээр нь бүрэн бүтэн, хэрэглэгдэж байгаа эсэхэд шалгалт хийнэ.

5.3. II дугаар шатны хяналтын явцад дараахь зүйлийг шалгана. Үүнд:

- I шатны хяналтын үр дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдал;
- Ажлын байрны нөхцөл байдал нь ХАБЭА-н шаардлагад нийцэж буй эсэх;
- Ажлын байрны аюулгүй зохион байгуулалт;
- Төвийн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал;
- Аюулгүйн тэмдэг, анхааруулах самбар, бичилт нь байгаа эсэх;
- ХАБЭА-н журам, дүрэм, зааврыг мөрдөж буй байдал;
- ХАБЭА-н сургалт, зааварчилгааг ажилтнуудад цаг тухайд нь чанартай явуулж байгаа эсэх, мэргэжлийн үнэмлэхтэй эсэх;
- ХАБ-ын заавар, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх ажилтнуудын мэдлэгийг түүвэрчлэн шалгах;
- Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл байгаа эсэх, тэдгээрийн иж бүрдэл, ашиглалтын бэлэн байдал;
- Томилолтоор ажиллах үеийн хамгаалах хэрэгсэл (ажлын тусгай хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгсэл)-тэй эсэх, бүрэн бүтэн эсэх;
- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдлыг хангаж байгаа эсэх
- Засгийн газар, яам, агентлаг, төрийн хяналтын байгууллагын тушаал, тогтоол, албан шаардлагын биелэлт;

5.4. ХАБЭА-н зорилтот хяналтын зорилго нь ажлын байрны эрганомикийн орчныг судлах зорилгоор ХАБЭА-н нөхцөл байдал болон ажил гүйцэтгэх үед ХАБЭА-г хангаж буй байдалд төлөвлөгөөт бус хяналт тавихад оршино.

6.2.1. ХАБЭА-н тухай хууль болон энэ журам, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дүрмийг чанд мөрдөн ажиллах;

6.2.2. ажил үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;

6.2.3. ХАБЭА-н сургалтад хамрагдсан байх, шаардлагатай тохиолдолд шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх;

6.2.4. эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт заавал хамрагдсан байх;

6.2.5. ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, аюул ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;

6.2.6. өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд оруулахгүй байх;

6.2.7. ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан ХАБЭА-н шаардлагыг биелүүлэх;

6.3. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Долоо.Бусад

7.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогч, ажилтан болон хөдөлмөр эрхэлж буй этгээдийн хооронд үүссэн маргааныг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү журмыг 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.